ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
6 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**2017.06.20**

***Газрын удирдлагын хэлтэс:***

*Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөл:*

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын даалгаврыг боловсруулан батлуулахаар ажиллаж байна

Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний албан даалгаварыг боловсруулж батлуулсан /3 сумаар/


БАТЛАВ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА
Ц.ТАНХҮҮ

БАТЛАВ
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Г.БАТСУУРЬ

"ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ БОЛОВСРУУЛАХ" АЖЛЫН ДААЛГАВАР

2017 оны....сарын ....-ны өдөр Дугаар Улаанбаатар хот

| д/д | Ажлын нэр, төрөл | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Ажил гүйцэтгэх үндэслэл | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх үндэслэл: 1. Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь заалт 2. УИХ-ын 2001 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 57 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал" 3. УИХ-ын 2008 оны 1 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого" 4. УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр" 5. УИХ-ын 2010 оны23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол мал хөтөлбөр" ... |



Аялал жуулчлалын зориулалтаар 2 байршилд 2 га газрыг, сургалтын зориулалтаар 0,48 га газрыг, 18 дугаар зөрлөгийн баруун талд үйлдвэрлэлийн цогцолбор паркийн зориулалтаар 3000 га, Шар хад, уул худагт тариалангийн зориулалтаар 1000 га тус тус Сүмбэр сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр батлагдлаа.

Орлого төвлөрүүлэлт:

- Газрын төлбөрийн орлогын мэдээг сар бүр гаргаж татварын хэлтэст хүргүүлдэг бөгөөд 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 44,7 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь орлогын төлөвлөгөө 49,6%-ийн биелэлттэй байна. Цаашид төлбөрийн орлогыг нэмэгдүүлэхээр нэхэмжлэх бичин тараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- Улсын тэмдэгтийн хураамжийг 2017 оноос эхлэн төвлөрүүлэн ажиллаж байна.

- 100220500941 дансанд - аймгийн төв болон Сүмбэр сум-450000
- 100220300941 дансанд – Шивээговь сум-70000
- 100220400941 дансанд – Баянтал сум – 68000 төгрөгийг тус тус төвлөрүүлж 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар нийт 588000 төгрөгийг төвлөрүүлээд байна.

**Дуудлага худалдаа, төсөлд сонгон шалгаруулалт:**

- 1 байршилд интернетээр дуудлага худалдаа зохион байгуулан ажиллаж байна.
- 3 байршилд төсөл сонгон шалгаруулалтыг зарлаад зарыг www.govisumber.gazar.gov.mnсайт, “Зууны мэдээ” сонинд байршуулан олон нийтэд ил тод зарлаад байна. Үүнд:

- Сүмбэр сумaнд "М-Ойл" ХХК-ийн зүүн талд худалдаа үйлчилгээний зориулалтаар 0,16 га газрын дуудлага худалдааг интернетээр зохион байгуулахаар /mle.mn хаяг/

- Хонхор хотхоны урд талд хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалтыг /2 байршилд 2,4 га газарт/ зохион байгуулахаар
- Сүмбэр суманд 300 га газрыг нарны эрчим хүчний зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор
- Шивээговь суманд 1-р багт 14 байрны хойд талд 0,12 га газрыг эмийн сангийн барилга барих зориулалтаар төсөл сонгон шалгаруулалт тус тус зохион байгуулахаар холбогдох газруудаас техникийн нөхцөл гаргуулж, бичиг баримтыг боловсруулж эхлээд байна.






**Геодези, зураг зүй:**

Геодезийн байнгын цэг тэмдэгт орон нутгийн өмчид бүртгэгдэж, төрийн хадгалалт хамгаалалтанд байхтай холбогдуулан 3 сумын төвийн геодезийн цэг тэмдэгтийг сэргээн засварлах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авахаар удирдамж боловсруулан, газрын даргаар батлуулан ажиллаж 2017 оны 06 дугаар сарын 10-нд Сүмбэр, Баянтал сумдад ажилласан.

- Сүмбэр суманд 13 цэг тэмдэгт
- Баянтал суманд 5 цэг тэмдэгтийг газар дээр нь очиж тооллого хийж, сэргээлээ.





2017 оны 06 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд Шивээговь болон Баянтал суманд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр ажиллаж тайланг байгууллагын даргад танилцуулсан. 2 суманд нийт 109 иргэнд үйлчилгээ үзүүлж, гарын авлага материал тарааж, зөвлөгөө өгч ажилласан. Үүнд:

- Кадастрын зургаар 30 иргэнд
- Газрын хэмжилт 18 нэгж талбарт
- Газар өмчлөх өргөдөл 18 иргэн

- Өмчилсөн газраа баталгаажуулж үл хөдлөхийн гэрчилгээ авсан 18 иргэн
- Газар өмчлөх материал 6 иргэнд хүлээлгэн өгч
- Гаражийн газрын эрх шилжүүлэхээр хуваалгасан кадастрын зураг 8 иргэнд
- Газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг 1 иргэнээс хүлээн авч ажилласан.





**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

1. ГЗБГЗЗГ-аас ирсэн шалгалтад барилга, барилгын материал, орон сууц, нийтийн аж ахуй, хот байгуулалт, норм нормативын сангын бүрдүүлэлт, бүтээн байгуулалтын ажил, барилгын материалын лабораторийн үйл ажиллагааны чиглэлээр холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган, ажлыг танилцуулж ажилласан.

**Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах ажлын хүрээнд:**

1. Сүмбэр суманд баригдах “Нарны цахилгаан станц”
2. Шивээговь сумын 1-р баг, “Эмийн сан”-гийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварыг тус тус боловсруулсан.

**Мэдээ тайлан:**

1. МУ-н үндсэн чиглэлийн биелэлт
2. ЗГҮАХөтөлбөрийн биелэлт
3. Тогтоол шийдвэрийн биелэлт
4. Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт зэргийг хагас жилийн байдлаар гаргасан.

Ажлын төсөв, тооцоо боловсруулах ажлын хүрээнд:

1. Орон сууцны барилгын орцны саравч, хогийн сав, сандалын төсөвт өөрчлөлт хийж төсвийг боловсруулсан. /28 сая төг/
2. Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгийн хашааны ажлын төсвийг боловсруулсан./58,7 сая төг/
3. Сүмбэр сумын 2, 3-р багийн гүний болон зөөврийн 3 худгийн шинээр барих 2, засварлах 1 худгийн ажлын төсвийг боловсруулсан. /40,0 сая төг/

Техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хүрээнд:

1. Усан спортын барилгын засварын ажлын техникийн тодорхойлолт
2. Сүмбэр сумын 3-р багийн Орон сууцны гадна хийгдэх хогийн сав, сандал хийх ажлын техникийн тодорхойлолт зэргийг тус тус боловсруулсан.

**Барилгын техник хяналтын чиглэлээр:**

- Сүмбэр сумын 3-р баг, 5 дугаар сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны гадна тохижилтын ажил: Ажлын гүйцэтгэл 100% хийгдсэн. Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн гаргах шатандаа байна.



- Сүмбэр сумын 3-р баг, 5 дугаар сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны гадна фасад, Б-корпусын засварын ажил: Ажлын гүйцэтгэл 100% хийгдсэн.. Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн гаргах шатандаа байна.





- Баянтал сумын Соёлын төвийн барилгын дээвэр засварын ажил: Ажлын гүйцэтгэл 15%-тай хийгдэж байна.



- *эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох ажлын хүрээнд:*

1. Баянтал сумын Соёлын төвийн дээвэр засварын ажил
2. Баянтал сум 4-р сургуулийн спорт зал хэсэгчилсэн засварын ажил
3. Аймгийн төвийн гудамж талбайн камержуулалтын ажил зэрэгт тус тус зөвшөөрлийг олгоод байна.